

**ГАДААД ХЭРГИЙН САЙД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2001 оны 1 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 05/06

Улаанбаатар
хот

**Адилтгах албан тушаалын жагсаалт
батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүн, дунджийг тодорхойлох журам”-ын 4 дүгээр заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол улсаас гадаад орнуудад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад ажиллаж буй албан хаагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох болон хүн амын орлогын албан татварын тооцоо хийх хөдөлмөрийн хөлсийг тодорхойлоход баримтлах адилтгах албан тушаалын жагсаалт”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Олон улсын байгууллагад томилолтоор ажиллаж буй Монгол улсын иргэд болон Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж буй төвийн томилолттой ажилтны гэр бүлийн хүмүүсийг нийгмийн даатгалд сайн дурын үндсэн дээр даатгуулах ажил зохион байгуулж, энэхүү тушаалыг мөрдөж ажиллахыг Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг 2001 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жанцан, Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын дарга Б.Гомбо нарт үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулж “Адилтгах албан тушаалын жагсаалт батлах тухай” Гадаад харилцааны сайд, Хөдөлмөрийн сайдын хамтарсан 1991 оны 72/72 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАДААД ХЭРГИЙН САЙД

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Л.ЭРДЭНЭЧУЛУУН

Ши. БАТБАЯР

Монгол улсаас гадаад орнуудад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад ажиллаж буй албан хаагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох болон хүн амын орлогын албан татварын тооцоо хийх хөдөлмөрийн хөлсийг тодорхойлоход баримтлах адилтгах албан тушаалын жагсаалт

№	Гадаадад ажилласан албан тушаал	Адилтгах албан тушаалын
1	Элчин сайд, Байнгын төлөөлөгч	Дэд сайд
2	Элчин зөвлөх, Хэргийг түр хамаарагч, Байнгын төлөөлөгчийн орлогч, Ерөнхий консул, Батлан хамгаалахын атташе	ГХЯ-ны газрын захирал
3	Зөвлөх	ГХЯ-ны газрын дэд захирал
4	1 дүгээр нарийн бичгийн дарга, Консул	1 дүгээр нарийн бичгийн дарга
5	2 дугаар нарийн бичгийн дарга, Дэд консул	2 дугаар нарийн бичгийн дарга
6	3 дугаар нарийн бичгийн дарга	3 дугаар нарийн бичгийн дарга
7	Атташе, Батлан хамгаалахын атташегийн туслах, ахлах нягтлан бодогч, нууцын эрхлэгч-холбоочин	Атташе, ахлах нягтлан бодогч, нууцын эрхлэгч-шифрлэгч
8	Төвийн томилолттой үйлчилгээ техникийн ажилтан (сантехникч, аж ахуйн эрхлэгч, жолооч)	Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын үйлчилгээ техникийн ажилтнуудын ижил төрлийн ажил албан тушаал